

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Дорнод 10 № 1-6/47
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Г.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	874.5	822.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,318.2	7,184.6
	Нийт хөрөнгийн дүн	6,192.7	8,007.1
	Нийт өр төлбөрийн дүн	1.7	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,191.0	8,007.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,192.7	8,007.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,256.6	6,104.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,816.0	4,283.4
	Үйл ажиллагааны үр дүн	1,440.6	1,820.9
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,440.6	1,821.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,867.2	6,186.2
	Тайлант оны үр дүн	1,440.6	1,820.9
	Эцсийн үлдэгдэл	6,192.7	8,007.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,624.4	3,325.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,617.1	3,313.9
	Үйл ажиллагааны ЦМГ	7.3	11.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-7.3	-11.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,374.6	2,328.6
	Урсгал зардал	2,374.6	2,328.6
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	2,404.6	2,415.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Онцгой байдлын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтыг сайжруулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

2. Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацийг нэвтрүүлэх.
3. Байгууллагын удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх.
4. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах.
5. Гамшгаас хамгаалах мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх.
6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх замаар галын аюулгүй байдлыг хангах, гал түймэртэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах.
7. Улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулж, гамшгийн дараах үйл ажиллагааг эрчимжүүлэх.
8. Төсөв санхүү, хангалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх
9. Гамшгаас хамгаалах хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоод хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ” гэж заасны дагуу тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд иргэн, ААНБ-аас нийт 237.2 сая төгрөг төвлөрснөөс 231.5 сая төгрөгийг зарцуулж, 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллага ОБЕГ-аас 2,345.0 сая төгрөгийн, ТИКА төслийн хүрээнд 29.8 сая төгрөгийн, дотоод шилжүүлгээр 207.6 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 54.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг хүлээн авч, бүртгэлд тусгасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Онцгой нөхцөл байдлын үед байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрдөг хүмүүнлэгийн тусламж буюу хандивын хөрөнгийн бүртгэл, зарцуулалтыг авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 87.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 65.5 сая төгрөгийн алдааг залруулж, 21.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны мөнгөн гүйлгээний журналыг эдийн засгийн ангилал тус шүүж үзэхэд жилийн эцэст нийт 139,451.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс үндсэн үйл ажиллагаанаас 73,919.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 65,532.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Гэтэл нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайлагнаагүй буюу төсвийн хэлбэлзлээс зөрүүтэй тайлагнасан байна

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд нийт 138.8 сая төгрөгийн албан томилолт олгосон байна. Томилолтыг "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 50.2-т "Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно" гэж заасны дагуу тооцож олгосон байна. Албан томилолтыг түүвэрлэн авч үзэхэд зарим алба хаагчид үндсэн үүрэгт ажлаа хийсэн байтал албан томилолтыг Гамшгийн тухай хуулийн дээрх заалтыг баримтлан тооцсон албан томилолтын нөхөн олговор тооцож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дахь хэсгийн 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөн олговор олгоно" 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ. 2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал", "Гамшгийн тухай хууль"-ийн 50 дугаар зүйлийн 50.2-т "Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно" гэж заасантай нийцээгүй байна.
2. Нэмэлт санхүүжилтийн дансанд хандивын 237.2 сая төгрөг төвлөрснөөс 231.5 сая төгрөгийг зарцуулж, 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зарцуулалтын анхан шатны баримт, холбогдох тушаал шийдвэрийг шалгахад 1.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Мөн дархлаажуулалтын багц худалдан авсан байгаа ба тус багцад худалдан авсан бараа тодорхойгүй, бараа материалын тайланд хүнсний материалаар бүртгэсэн, худалдагч талын анхан шатны баримтад худалдсан барааны нэр байхгүй, e-barimt байхгүй байна. Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгаас хамгаалах дотоод хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 4 дэх хэсгийн 4.7-д "Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, тэмцэх, аврах, эрэн хайх, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэхээс бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

3. Тус байгууллага нь 2021 оны 11 сарын 15-нд Нэкст электроникс ХХК-аас 3.3 сая төгрөгийн үнэ бүхий Samsung телеюизор /хичээл үйлдвэрлэл, дадлагын зардлаас/ БСБ компьютерс ХХК-аас нийт 7.2 сая төгрөгөөр компьютер /хичээл үйлдвэрлэл, дадлага болон БГАҮТХ-ын зардлаас/ худалдан авсан байна. Мөн БГАҮТХ-аас шагнал, мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 10 сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 2108, 210902 дансны тодорхойлолтод заасантай нийцэхгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 199.7 сая төгрөгийн хандив төвлөрч, бүртгэж, тайлагнасан байна /өмнөх оны үлдэгдэл 37.5 сая төгрөг байх ба нийт 237.2 сая төгрөгийн хандивын хөрөнгө төвлөрсөн байна/. Хэдийгээр нийт сумдад өгсөн хандивыг бүртгэж төвлөрүүлсэн гэх боловч нотлох боломжгүй, тодорхой хяналт тавьж ажиллаагүй байна.

- 1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”, Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ” гэж гэж тус тус заасны дагуу сумдад иргэн, ААНБ-аас төвлөрч байгаа хандивын хөрөнгийг бүрэн бүртгэх, хяналт тавих, хууль, тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлж ажиллах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	87.3	1	65.5			3	21.8	1	
	НИЙТ	4	87.3	1	65.5			3	21.8	1	